

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2021-03-31/**

Ажлын хэсгийн 54 дүгээр хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 15.00 цагт цахим хэлбэрээр зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалыг орлож Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, шинжээч Г.Мишээлт, татварын ерөнхий газрын байцаагч Э.Батцэнгэл, АТГ-ын ажилтан Б.Ганхуяг, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтэн П.Золзаяа, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Оюутолгой ХХК-ийн, ахлах менежер Т.Мөнхбат, Эрдэнэс монгол ХХК-ийн Дотоод хяналт, мониторингийн албаны дарга Баттулга, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн Д.Сүхбаатар, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнпүрэв, Их баяншарга ТББ-ын тэргүүн Л.Бор, болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 16 гишүүн оролцож, ирц 48,48 хувьтай байв.

Мөн хуралдаанд Дэлхийн банкны Санхүүгийн корпорацийн зөвлөх Б.Дэлгэрмаа, ОУИТБС төслийн зохицуулагч З.Баярхүү, Мэдээлэл технологийн зөвлөх В.Нармандах, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны газрын дарга Э.Батболд нээж, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон удирдав.

Э.Батболд: Сайн байцгаана уу, хоцорсонд уучлаарай. Би давхар хуралтай байгаа, одоо Мишээлт ороод ирэх байх, ажлын хэсгийн хурлаа эхэлье. Өнөөдрийн хуралдаанаар гэрээний ил тод байдлын цахим сайтын ажиллагааг хэрхэн үргэлжлүүлэх талаар бага хурал зохион байгуулах тухай ярилцах юм байна. Та бүхэн идэвхтэй оролцож саналаа өгнө үү, баярлалаа.

Танилцуулга нэг: Гэрээний ил тод байдлын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний тухай

Д.Эрдэнэчимэг: Сайн байцгаана уу, гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Юуны өмнө бидний саналыг хүлээн авч, гэрээний ил тод байдлын тухай хэлэлцэх ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж байгаа УУХҮЯ, Ажлын хэсэг болон ажлын албанд талархал илэрхийлье. ННФ болон УУХҮЯ-ны хооронд 2017 онд Санамж бичиг байгуулсан. Гэрээний ил тод байдал нь ОУИТБС-ын голлох шаардлагын нэг бөгөөд 2019 оноос заавал биелүүлэх шаардлага болж, хэрэгжүүлэгч орнууд 2021 оны 1 сар гэхэд гэрээний ил тод байдлыг хангасан байх ёстой гэсэн үүргийг хүлээсэн. Энэ хүрээнд бид ажиллаж байна. Мөн Нээлттэй засаглалын түншлэлийн хүрээнд энэ салбарт гэрээний ил тод байдлыг хангах амлалтыг төр авч, УУХҮЯ хэрэгжилтийг хариуцах байгууллагаар ажиллаж байна. Үүний дагуу гэрээний мэдээллийн цахим санг хөгжүүлж, 2019 оны 4 сард олон нийтэд нээлтээ хийсэн байгаа. Одоогийн байдлаар гэрээний сайтад 805 орчим гэрээ байршсан байгаа. Сайт маань гэрээнүүдийг газрын зураг дээр засаг захиргааны нэгжтэй холбож оруулдаг, гар утас, таблет зэрэг жижиг дэлгэцтэй төхөөрөмжөөр ороход бүтэц нь өөрчлөгдөхгүй, “responsive design”-тай. ОУИТБС-ын Цахим тайлангийн системтэй мэдээллээ солилцдог, гэрээний мэдээллийг оруулахад тухайн компанийн регистрийн дугаар, лицензийн дугаар зэрэг мэдээллийг шууд татахаар хийгдсэн байгаа, PDF, зураг гэх мэт ямар ч форматаар ирсэн гэрээг текст хэлбэрт хөрвүүлэн оруулах боломжтой,

Гэрээний вэб сайтыг хийхдээ олон улсад ашиглаж байгаа “source” кодыг ашиглаж хийсэн учир давуу талтай. Одоогоор 14 төрлийн 805 гэрээ байгаа. Ихэнх гэрээг 2019 онд

оруулсан, 2020 онд маш цөөн гэрээ оруулсан. УУХҮЯ-ны оролцоо сайн байсан, харин 2020 онд гэрээ цуглуулж оруулах ажил зогсонги байдалд орсон, гэрээ татаж оруулах ажил хийгдээгүй байна. Цаашид яамдууд гэрээ оруулах боломжтой, ихэнх гэрээнүүд орон нутгийн түвшинд байгуулагдсан гэрээнүүд байдаг. Цар тахлын нөхцөл байдлаас үүдээд орон нутагт цөөхөн гэрээ байгуулагдсан гэх мэдээлэл байгаа ч хэдэн гэрээ хийгдээд, хэд нь ороогүй байна гэдэг тоог авч чадаагүй байгаа. Аймгуудын ЗДТГ-ын уул уурхай хариуцсан мэргэжилтэнд нууц үг үүсгээд нэвтрэх эрх олгосон ба жил бүр УУХҮ-ийн сайдаас аймгийн Засаг дарга нартай байгуулдаг гэрээнд энэ асуудлыг тусгасан байдаг. УУХҮЯ-ны ажлын хэсэг дээр 2020 онд цуглуулсан 200 орчим гэрээ сайтад оруулахад бэлэн байгаа ч бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор ажлын хэсгийг шинэчлэн байгуулах шаардлагатай гэсэн шалтгаанаар тэдгээр гэрээг сайтад оруулах ажил саатаж байна. Одоогоор гэрээний сайтыг ННФ, Itools компанийн сервер дээр байршуулан ашиглаж байна.

Санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УУХҮЯ нь гэрээний ил тод байдлыг хуулиар баталгаажуулах, төрийн байгууллага, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага, хэрэгжилтийг дүгнэх хугацаа, журмыг тодорхой болгох, төрийн мэдээллийн сантай холбох, ОУИТБС ажлын алба нь сайтыг хүлээн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, ННФ нэмэлт хөгжүүлэлт, гэрээний тайлбар, судалгаа олон нийтэд хүргэх ажлуудыг зохион байгуулах нь зүйтэй. /Танилцуулгыг хавсаргав/

Ш.Цолмон: За баярлалаа, танилцуулгатай холбоотой санал, асуулт байвал хэлнэ үү. УУХҮЯ-наас энэ оны 7 сарын 1-ны дотор ажлын алба гэрээний сайтыг хүлээн авах чиглэл өгсөн.

Н.Баярсайхан: Энэ асуудал нь цаг үеэ олсон асуудал байна. Эрдэнэчимэгийн илтгэл дээр нэмж хэлэхэд, манай байгууллага стратегийн бүс нутгийн 4 аймгийн гэрээний ил тод байдалд шинжилж үзэхэд 2020 онд дөрвөн аймгаас ердөө дөрөвхөн гэрээ байршуулсан байдаг. Энэ нь Орон нутгийн гэрээ 2, ус ашиглах гэрээ 2 л байна. Гэрээ байгуулаагүй биш, байгуулсан. Бэлхэн цахим талбарт байгуулсан Гэрээгээ оруулаагүй байгаа юм чинь гэрээгээ дүгнэсэн эсэх нь эргэлзээтэй. Бид ОУИТБС-тайланг хялбар байдлаар гаргах, мэйнстрим болоход чиглэж байгаа. Гэтэл маш их ажил, хөрөнгө зарцуулж хийсэн гэрээний сайтыг УУХҮЯ авч явж чадах уу гэдэг эргэлзээтэй байна. Иймд 1-р асуудлын шийдвэрийн төсөл дээр нэмээд яаралтай ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, хуралдаанд УУХҮЯ 1-рт, iltodgeree.mn сайтыг цаашид хэрхэн бусад төслийн ажлууд, үндсэн чиг үүргийн хүрээнд хэрхэн нэгтгэж авч явах, бусад засаглалыг сайжруулахтай холбоотой олон ОУ-ын төслүүдийг хэрхэн уялдааг хангах талаар байр суурь, зохицуулах талаар асуудал оруулах саналыг хурлын шийдвэрт оруулах хүсэлтэй байна, байдаг л нэг унжгар сул шийдвэр гаргамааргүй байна. Зөвхөн гэрээг байршуулаад орхидог биш, гэрээг дүгнэсэн дүгнэлтийг оруулдаг баймаар байна, УУХҮЯ дотроо хэнд хаанаа хариуцуулах, АМГТГ дээрээ хариуцуулах юм уу энэ бодлогоо маш тодорхой болгомоор байна. Үндэсний түвшинд нэг ойлголт, нэгдсэн нэг удирдлагатай болгох ойлгомжтой зохицуулсан томоохон шийдвэр гаргах саналтай байна.

Л.Бор: ННФ олон жил гэрээний талаар ажиллаж, авч явж байна. Гэрээний сайтыг яам авах нь зөв гэхдээ УУХҮЯ-ны мэдээлэл ил тод биш, ажиллахад хэцүү байдаг. Хамтын ажиллагааны гэрээнээс гадна томоохон стратегийн гэрээнүүдийг оруулах шаардлагатай байна. Том гэрээнүүд нь англи хэл дээр өчнөөн хуудас гэрээ байдаг түүнийг яаж оруулах вэ? Газрын тосны гэрээг оруулах шаардлагатай, гэрээ хийсэн компаниуд нь олдхоо больсон байдаг. ИНБ-ыг дандаа шүүмжилдэг гэж хэлдэг, бид үр хүүхдийнхээ ирээдүйн төлөө дуугарах хэрэгтэй байх. Гэрээний талаар ярьвал асуудал их байна, уул уурхайгаа яаж цэгцлэх талаар залуучууд ажилламаар байна. Улс орноо улс орон шиг байлгая гэвэл уул уурхайгаа цэгцэлмээр байна. Баярлалаа.

Д.Эрдэнэчимэг: Зөвхөн гэрээ төдийгүй, гэрээтэй холбоотой бусад баримт бичгүүдийг оруулах саналыг Баярсайхан гишүүн хэлж байна, энэ зөв санал байна. Холбоотой баримт бичгүүдийг оруулах шийдэл нь сайтад байгаа ч харамсалтай нь бид гэрээг оруулахад илүү

анхаарч гэрээний хэрэгжилтийн мэдээлэл, тухайн төслийн БОНБНУ тайлан зэрэг холбогдох мэдээллийг оруулах ажил хийгдээгүй байгаа. Хөрөнгө оруулалтын, БХГ зэрэг засгийн газрын хэмжээнд байгуулагддаг томоохон гэрээнүүд бүгд орсон, ганцхан цацраг идэвхт ашигт малтмалын орд ашиглах гэрээ нууцлалын зэрэгтэй гээд оруулаагүй байгаа. Одоогоор АМГТГ-т энэ төрлийн гэрээ 3 байдаг гэсэн мэдээлэл бий. Мөн БХГ-ний үндсэн нөхцөлийг сайтад оруулахдаа дарсан байгаа нь мөн нууцлалтай холбоотой. Гэхдээ нууцлалын асуудал маргаантай, 2015 онд БХГ-ий загварыг шинэчлэн батлахад нууцлалын заалтыг хассан ба УУХҮЯ-аас БХГ-нийг шинэ загвараар шинэчлэн байгуулах ажил хийгдэж байгаа. Тэгэхээр шинээр байгуулагдсан гэрээнүүдийг бүхлээр ил болгох хэрэгтэй ч одоог хүртэл төрийн зүгээс болгоомжлол байгаа учраас үндсэн нөхцөл хаалттай хэвээрээ байгаа.

Г.Мишээлт: Ажлын хэсгийн гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Мэдээллийг сонслоо, Эрдэнэчимэгт баярлалаа. Гэрээний сайтыг УУХҮЯ-нд шилжүүлэх талаар яамны хуулийн хэлтэстэй ярилцаж дарга нарт танилцуулсан. Хэрвээ яаманд сайтыг хүлээж авбал ИНБ-ын хэлснээр ажил цалгардах магадлалтай. Яаманд авахад хуулийн хэлтэс хариуцах болно, гэвч гэрээтэй холбоотой ажлыг хийх чиг үүрэг нь бидэнд байхгүй байгаа. Хэрвээ Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хууль батлагдаад явбал эрхзүйн орчин нь тодорхой болох юм гэсэн үндэслэлээр ажлын албанд шилжүүлэх нь зүйтэй гэж үзсэн, гэвч ажлын албанд ирснээр компаниуд ажлын албаны шаардлагыг хүлээж авахгүй, мэдээллээ өгөхгүй байх асуудал гарч магадгүй юм. 2021 оны 7 сарын 1-ны дотор шилжүүлж авахаар ярьж байгаа, энэ хүртэл бид эргээд энэ асуудлыг ярилцана, ажлын албанд ирсэн тохиолдолд яам ажлын албаны хооронд журам гаргаад зохицуулах нь зүйтэй байна гэсэн шийдвэр гаргасан. Хэрвээ ажлын албанд Гэрээний сайтыг хүлээж аваад, мэдээллийн шинэчлэл нь хийгдээд, үйл ажиллагаа нь цаашдаа журмаар зохицуулагдаад явах нь илүү оновчтой гэж үзсэн үндэслэлээр шийдвэрийн төсөлд оруулсан байгаа.

Ш.Цолмон: За баярлалаа, шийдвэрийн төсөлд санал хураая.

Н.Баярсайхан: УУХҮЯ ямар бодлого барьж байгаа талаар нэг ойлголттой байх үүднээс асуудлаа боловсруулаад, Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулах санал байна. ОУИТБС-ыг цаашид яаж авч явах талаар нэгдсэн бодлого, ойлголтыг бий болгох хэрэгтэй байна. Дэд сайд Батнайрамдал сайхан зүйл их ярьж олон газар илтгэл танилцуулга хийж байна, төрийн нарийн бичгийн дарга нь бас өөр юм хийж явдаг энэ зарчмын өөр өөр байр суурь, үйлдлээ нэгтгэсэн бодлогоо танилцуулах, нэгдсэн ойлголт өгөх хэрэгтэй байна. Үндэсний зөвлөлийг ахалж байгаагийн хувьд, салбарын асуудал хариуцаж байгаагийн хувьд УУХҮЯ бодлогоо танилцуулж, бүх шатанд ажил хариуцсан хүмүүсийн чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож өгмөөр байгаа учраас энэ санал гаргасан. Энэ саналаа томъёолж өгч болно.

Б.Ганхуяг: Сайн байцгаана уу, 2020 оноос уул уурхайн асуудлыг хариуцах болсон. ОУИТБС-ын талаар 2021 оноос мэдээлэл ойлголт авсан. Бид УУХҮЯ болон ажлын албатай Эрдэс баялгийн ил тод байдлын хуулийн талаар хэлэлцүүлэгт оролцоно, цаашид хамтран ажиллахад бэлэн байна.

Д.Эрдэнэчимэг: Журам боловсруулах ажлыг яам хариуцаж авах нь зүйтэй гэсэн саналтай байна. Мишээлтийн хэлсэнд эргэлзээ төрж байна.

Н.Баярсайхан: Журмыг нийтээр дагаж мөрдөж захиргааны шийдвэр гарах учраас Ажлын алба боловсруулж ОТОАХ батлах нь хуулиараа нийцэхгүй байх Иймээс яам хариуцах нь зөв гэсэн саналтай байна.

Л.Бор: Яамны хүмүүс ОУИТБС-ны ажилдаа гүнзгий ормоор байна. ОУИТБС-ын тайланг гаргадаг болоод 10 гаруй жил болж байна. 3000 гаруй компани байгаа ч ганц машины үнэ төлөхгүй байна, энэ нь хуулиндаа байна уу, юундаа байна. ДНБ-ын 20 хувь, улсын төсвийн 20 гаруй хувийг уул уурхайгаа бүрдүүлж байна гэж байгаа. Компани нь утсаа

авдаггүй, хаяг дээрээ байдаггүй, агентлаг нь ч сураг гаргаж чаддаггүй, авилгын асуудал их байна, яам, анхаарах хэрэгтэй байх зэрэг асуудлыг бодмоор байна.

3.Баярхүү: Хууль гартал Засгийн газрын тогтоолоор журмаа батлуулвал ямар вэ? Журманд яам ямар үүрэг оролцоотой байх компани, орон нутаг ямар оролцоотой байх талаар тусгах саналтай байна.

Г.Мишээлт: Засгийн газрын тогтоол хэрэггүй байх. УУХҮ-ийн Сайд 2021 онд аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан гэрээнд ОУИТБС-ын талаар мэдээ тайланг тогтмол хүргүүлж байх талаар нэг заалт оруулсан байгаа, үүнийг ажлын хэсэгтээ танилцуулаарай.

Танилцуулга хоёр: Монголын ОУИТБС-ын төвийн бүсийн чуулганы цахимаар зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах талаар

Ш.Цолмон: 2020 оны 11 дүгээр сард Төвийн бүсийн 4 дүгээр чуулганыг зохион байгуулахаар яригдаж байгаад хойшилсон. Энэ оны 5 дугаар сард цахимаар зохион байгуулахаар төлөвлөж байна. Үүнд УУХҮЯ, ТЕГ, БОАЖЯ, ТАН эвсэл, МБОИЗ болон компаниуд оролцоно. Нийт 8 аймгийн 5 сумыг хамруулан цахимаар 2 өдрийн сургалтыг зохион байгуулахаар хөтөлбөрийн төслийг боловсруулан танилцуулж байна. Эхний хэсэгт лиценз, орон нутгийн гэрээний асуудлаар танилцуулга хийнэ. Ямар компаниудыг оролцуулах талаар АМГТГ, Уул уурхайн ассоциаци хамтран ажиллаж, саналаа өгөхийг хүсэж байна. Анх удаа цахимаар олон аймаг сум, төрийн байгууллагыг хамарсан ажлыг зохион байгуулах гэж байгаа учраас зохион байгуулах дэд ажлын хэсэг байгуулах саналтай байна. Өөрсдийн зүгээс ямар хэлбэрээр хамтран ажиллах талаар та бүхний саналыг сонсоё. /хөтөлбөрийн төслийг хавсаргав/

Б.Дэлгэрмаа: Ажлын хэсгийн бүх гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Манай ОУСК-аас нээлттэй өгөгдлийг хэрхэн ашиглах талаар датаконыг зохион байгуулсан. Нээлттэй өгөгдөлд ОУИТБС-ын мэдээллийг суурь болгож байгаа. 2021-2022 оны төлөвлөгөөнд ОУИТБС-д дэмжлэг үзүүлэхээр зорьж байна. ОУИТБС-ын тайлангийн хавсралт мэдээллийг орон нутгийн иргэд ашиглахад бэрхшээлтэй байгаа гэж үзэж байгаа иймд мэдээллийг нэгтгэх, стандартад оруулах, нээлттэй өгөгдөл хэлбэрээ Нээлттэй өгөгдлийн санд байршуулах, ашиглахад хялбар болгох, хоёрдугаарт аймаг бүрийн инфографикийг боловсруулах форматтай болгох зорилттой байна. Мөн дөрвөн бүсийн семинарыг зохион байгуулахад хамтран ажиллана. Бүсийн семинарыг хуралдаад өнгөрөх биш одоо байгаа өгөгдөл дээрээ ажиллаж сурах, орон нутагт яг болохгүй байгаа асуудлаа гаргаж тавих байдлаар зохион байгуулахаар чуулганы хөтөлбөрөөс эхлэн ажиллаж байна. Чуулганы өмнө орон нутгийн дэд зөвлөлийн гишүүдэд байгаа дата өгөгдлөө хэрхэн ашиглах талаар чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулна. Мөн 9-р сард мэдээллийг хэрхэн ашиглах талаар ажиллах сургагч багш бэлтгэх 40 хүний сургалтын зохион байгуулна. Үүнд орон нутгийн дэд зөвлөлийн гишүүдээс оролцуулна мөн ажлын хэсэг, ажлын албанаас тус бүр хоёр ч юмуу хүнийг хамруулах боломжтой байгаа. Цаашдаа өмнийн бүсийн дэд зөвлөлийг чадавхжуулах сургалт хийнэ. Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийнхөнд зориулан дээрх туршлага дээр үндэслээд оны сүүлээр нээлттэй өгөгдлийг хэрхэн ашиглах, цаашдаа үүнийг өргөн хүрээнд бодлогын түвшинд ашиглаж сурах вэ гэдэг талаар үндэсний хэмжээний томоохон семинар зохион байгуулахад ОУСК дэмжлэг үзүүлэх боломжтой. Мөн комик ном гаргах ажилд яамтай хамтран ажиллана, ирэх долоо хоногт хурал хийнэ. Цаашид Баярсайхан гишүүний хэлснээр засаглалыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа байгууллага төсөл хөтөлбөрүүд нэгдсэн нэг ойлголттой, чиглэлтэй байх талаар яам илүү санаачилга гаргаж ажиллах нь зүйтэй гэсэн саналыг дэмжиж байна. 4 сард болох Дэд зөвлөлийн уулзалтанд мэдээллийг хэрхэн ашиглах талаар хэд хэдэн жишээ тайлбар бэлтгэн үзүүлж болно. Баярлалаа.

Н.Баярсайхан: Ажлын алба дэд зөвлөлийн чадавхжуулах зорилтын хүрээнд цуврал уулзалтыг зохион байгуулж байгаа. Өмнө уулзалтаар орон нутгийн дэд зөвлөлөөс босоо

тогтолцоотой төрийн байгууллагын холбогдох хүмүүсийг дэд зөвлөлд идэвхитэй оролцоотой байлгахыг дээд байгууллагаас нь үүрэг чиглэл өгүүлэх хүсэлт гаргасан. Иймд АТГ, УБЕГ болон татварын байгууллагын хүмүүсийг оролцуулах нь зүйтэй. Мөн аймгуудын уул уурхай хариуцсан ажилтнууд ямар бодолтой байна зэрэг тулгамдсан асуудлыг ярих нь зөв бай, тэгэхгүй бол, хууль журам, эрхзүйн орчин яриад эсвэл том, том 2050 энэ тэр яриад дэмий байх. Илүү амьдралд ойрхон практиктай бодит асуудлыг ярих, ИНБ ямар оролцоотой байх, яам ямар оролцоотой байх, компани ямар үүрэгтэй байх талаар яамны зүгээс бодлого, байр сууриа илэрхийлж оролцох нь хэрэгтэй. Мөн БОАЖЯ-ыг хийж байгаа ажлын, баримталж буй бодлогын талаар илтгэл тавьж оролцуулах нь зүйтэй. Мөн шинэ стандартаар жендерийн асуудал орсон байгаа, иймд Жендерийн үндэсний хороог оролцуулвал илүү үр өгөөжтэй болох стандартаа баримталсан ажил болох байх. Магадгүй бүх асуудлыг нэг дор ярих боломжгүй байх гэхдээ олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд аль болох стандартаа хангаж ажиллахад суралцах хэрэгтэй байх. Баярлалаа.

Д.Энхболд: Компаниудыг оролцуулахад ассоциацийн зүгээс боломжоороо хамтарч ажиллая

Д.Эрдэнэцэцэг: Гишүүн байгууллагууддаа танилцуулаад саналаа хүргүүлье.

Ш.Цолмон: Ажлын хэсэгт орох саналтай хүмүүс байна уу, эргээд саналаа өгч болно. Дэлгэрмаа дэмжээд ажиллах байх.

Б.Дэлгэрмаа: Ажлын хэсэгт ажиллах боломжтой, дата өгөгдлөө хэрхэн ажиглаж илтгэл тавих талаар бэлтгэл ажилд оролцоно.

З.Баярхүү: Ажлын албан дээр уулзсан уулзалтын дагуу хөтөлбөрийн хар зургийг гаргасан байгаа энэ хөтөлбөр нилээд өөрчлөгдөх байх. Хөтөлбөрөө эцэслээд дараа нь зохион байгуулалтын талаар төлөвлөгөө боловсруулах байх.

Т.Мөнхбат: Чуулганы үеэр байгууллагын үйл ажиллагааг танилцуулж оролцож болно.

Н.Баярсайхан: Оюутолгой ХХК Өмнөговь аймгийн Дэд зөвлөлд яаж ажиллаж байгаа талаар ярьвал илүү өгөөжтэй болох байх. Сэдэвтэйгээ холбогдуулаад туршлага, сургамжийн талаар ярьвал оролцож байгаа хүмүүстээ тухайн орон нутагт тулгарсан асуудлыг шийдэхэд дөхөм байх. Ер нь чуулганы зохион байгуулах ажлын хэсгийн Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яам ахлаад явах нь зүйтэй ажлын албанд даатгаад орхиж болохгүй, ажлын алба ТАН эвслийн зохион байгуулсан ажил болчихвий, УУХҮЯ эсвэл АМГТГ-ын нэг нь ажлын хэсгийг удирдаж ажиллах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Б.Дэлгэрмаа: Баярсайхан гишүүний гаргасан Оюутолгой компанийн дэд зөвлөлтэй хамтран ажилладаг туршлага, Говийн оюу сангийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл хийлгэх саналыг дэмжиж байна.

Н.Баярсайхан: Ажлын хэсэгт өөрийн саналаар орж ажиллая, хөтөлбөрийн сэдэв болон оролцох байгууллагыг илүү тодорхой болгомоор байна.

Л.Бор: Чуулганд оролцох сум, аймгуудыг хэрхэн сонгосон бэ?

Ш.Цолмон: Бүсээр нь ангилсан, дэд зөвлөлийн туршлагаа танилцуулж оролцож болно. Идэвх санаачилгатай оролцсон гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн хуралдаан ажил хэрэгч, үр дүнтэй боллоо. Та бүхэндээ баярлалаа.

Шийдвэр:

1. Гэрээний ил тод байдлын шаардлагын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний тухай танилцуулах, гэрээний ил тод байдлын цахим сайтыг зохих бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр 2021 оны 7-р сарын 1-ний дотор ОҮИТБС-ын Ажлын албанд хүлээлгэн өгөхийг Нээлттэй Нийгэм форумд (П.Эрдэнэжаргал) зөвлөмж болгов.
2. Гэрээний ил тод байдлын цахим сайтыг ажиллуулах журмыг боловсруулж, 2021 оны 7-р сарын 1-ний дотор батлуулахыг ОҮИТБС-ын ажлын албанд (Ш.Цолмон) даалгав.
3. Монголын ОҮИТБС-ын Төвийн бүсийн чуулганыг цахимаар зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган цахимаар зохион байгуулахыг ОҮИТБС-ын ажлын албанд (Ш.Цолмон) даалгав.
4. Үндэсний зөвлөлийг ойрын үед хуралдуулахыг УУХҮЯ-д хүсэлт болгож, хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг уялдуулах асуудлыг хэлэлцэж, тодорхой шийдвэр гаргуулах.

Хуралдаан 16.55 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн
дарга:

Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалж, тэмдэглэлийн хянасан:

УУХҮЯ-ны Хөрөнгө оруулалт, судалгааны
газрын дарга:

Э.Батболд

ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОҮИТБС-ын Ажлын албаны
Санхүүгийн ажилтан

А.Отгонтунгалаг